



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 18 сарын 26 өдөр

Дугаар 822

Улаанбаатар хот

### Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 290,913,290.00 (хоёр зуун ерэн сая есөн зуун арван гурван мянга хоёр зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, хуристлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Г.Отгонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123007435  
37-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

**"ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХЕРӨНГӨД-БҮРТГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

№	Автомашины марк, улсын дугаар, зориуалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ОН	Балансын үнэ (төгрөгөөр)	Хурийтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	ТӨБЗГ-ЫН 2023 оны 474 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон доод үнэ (төгрөг)
1	Гинжит трактор Б10М.0110-1Е	2010.12.31	290,913,290.00	290,913,290.00	5,000,000.00	2,500,000.00
	Нийт дүн		290,913,290.00	290,913,290.00	5,000,000.00	2,500,000.00
			(хоёр зуун ерэн сая есөн зуун арван гурван мянга хоёр зуун ер)	(таван сая)	(хоёр сая таван зүү)	